



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/559

Есөнбулаг

Хөрөнгө хүлээлцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, 78.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 50 дугаар тогтоолын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдагдсан Орон нутгийн өмчийн газрын хөрөнгөд бүртгэлтэй Граж, агуулахын барилга (газар эзэмших эрхийн хамт)-ыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Баатарзориг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд: Х.Лхагважав (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Я.Зогсохжаргал (Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Б.Золзаяа (Орон нутгийн өмчийн газрын өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

2. Дуудлагын худалдаагаар худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль, журмын дагуу хийж ажиллахыг ажлын хэсэг (Х.Баатарзориг), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ